| 8 | | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тархвар зүйн судалгаанд тулгуурлан цахим системд төлөвлөж, гүйцэтгэлийг оруулах | 2021-2022 | ЗДТГ Мал эмнэлгийн тасаг | Улс, орон нутгийн төсөв | 192576 толгой мал хамруулса | 193000 толгой мал хамруулна. | | 142,4 | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга 331934 толгой мал, угаалга 256367, боловсруулалтанд 152617, туулгалтанд 331934 толгой мал арга хэмжээнд хамруулахаар төлөвлөж гүйцэтгэл халдварт:91,7% Шимэгчтэх: 99,8% Халдваргүйтгэл 30000 м2 талбай халдваргүйтгэхээр төлөвлөж гүйцэтгэл 100% тай байна. Сумын хэмжээнд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд боом 2787, ДХХ 82102, цусан халдварт 4792, дуут хавдар 1384, шөвөг яр 3950, сахуу 320, галзуу 4781, бруцеллёз 95750,нийт 195866 толгой мал хамруулсан байна. гоц халдвар шүлхий өвчны вакциныг үхэр сүрэгт хавар, намрын давтан тарилтаар 18634 , хонь 30954, ямаа 11450 толгой мал дархлаажуулалтанд хамрагдсан байна<br>Гүйцэтгэл 91,5%-тай байна. | 100 | |
| **2.3. Барилга, хот байгуулалт, газрын харилцаа** | | | | | | | | | | | |
| 1 | Зорилт 1. Сумын хөгжлийн хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу иргэдийг тав тухтай ажиллаж, | Бизнес хөгжлийн төвийн барилгын урсгал засварыг хийж, гадна, дотно өнгө үзэмжийг сайжруулна. | 2022-2024 | ЗДТГ/газрын даамал/ | Орон нутгийн төсөв | | Засвар хийгдсэн байна. | 40 сая | 36 сая | Бизнес хөгжлийн төвийн барилгын урсгал засварыг “Өрнөх мэргэн” ХХК хийж гүйцэтгэж байгаа, одоогоор хүлээлгэн өгөөгүй байна. | 90 | |
| 2 | | Наадмын талбай шинээр барина. | 2021-2024 | ЗДТГ/газрын | Орон нутгийн хөгжли | | Наадмын талбай | 30 | 29.563, 832 | Наадмын талбай шинээр барих ажлыг ”Баян их наяд ” констракшин компани шалгарч 6 дугаар сарын 3-ны өдөр гэрээ хийгдэн барилгын | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлнэ | | | даамал | йн сангийн хөрөнгө | | баригдсан байна. | | | ажлыг эхлүүлж хугацаанд нь буюу 7 дугар сарын 9-ны өдөр хүлээлгэн өгсөн. | | |
| 3 | | Ахуйн үйлчилгээний байрны дулааны шугам засварлаж, халуун ус, үсчин зэрэг үйлчилгээг тогтмолжуулна | 2020-2024 | ЗДТГ/газрын даамал | Орон нутгийн төсөв | | | | 20.0 | Ахуйн үйлчилгээний байрны дулааны шугамыг Өв дулаан ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. 4-р багийн иргэн Б. Оюунгуатай түрээсийн гэрээ хийж халуун усны үйлчилгээг тогтмолжуулав. | 100 | |
| 4 | | Сумын төвийн хатуу хучилттай 800 м авто замыг засварлана. | 2020-2024 | ЗДТГ/газрын даамал | Орон нутгийн хөгжлийн сан | 500м зам маш их эвдрэлтэй байгаа | Замын зураг төсөв хийх | - | - | 2021 онд Сумын төвд Их монгол хороололд нийт 400 метр хатуу хучилттай авто замын хажуу бродурыг сумын нийтийг хамарсан ажлын хүрээнд засварлав.<br>2022 онд авто замыг засварлуулах санхүүгийн дэмжлэг хүсч НИТХ,НЗДТГ, аймгийн Засаг дарга нарт албан тоотыг хүргүүлсэн. Замын хонхор хэсгүүдэд хайрга ,дайргаар дүүргэсэн. | 70 | |
| 5 | | Сумын төвийн хороолол гудамжийг цэгцэлнэ. | 2020-2024 | ЗДТГ/газрын даамал | Иргэдийн хөрөнгө | | газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу эмх цэгцтэй газар олголт хийж, стандартын дагуу бариулна | | 6.9 | 2022 оны 05 дугаар сарын 18-нд Сумын Засаг дарга М.Мөнхбаяр төрийн болон хувийн хэвшлийн байгууллага аж ахуй нэгжийн дарга, эрхлэгч нартай ӨГЛӨӨНИЙ ЦАЙНЫ уулзалтыг 2 удаа зохион байгуулж Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах зорилтот жилийн хүрээнд хийж хэрэгжүүлэх ажил, сумын түүхт 90 жилийн ойг угтан айл өрх албан байгууллага бүр хашаа хороо болон гадна орчны тохижилт хийх тал дээр анхаарч | 70 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | байгууллагын дарга нар ажилчдынхаа хашааг өнгө үзэмжийг нь сайжруулж, цэгцлүүлэх, айл өрхийн хогийг ажлын бус цагаар ачуулж байх гэр хорооллын айл өрхүүдийн хашааны гадна хураагдсан элсийг тухайн айл өрхтэй нь үнэ хөлсийг нь тохирон хог ачилтын машин, трактор 2-ыг ашиглан цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулах зэрэг асуудлыг хэлэлцэн хэрэгжилтийг зохион байгуулав.үүний үр дүнд байгууллага, ААН -үүд өөр өөрийн эзэмшлийн хашаа, хороогоо засварлаж будаж өнгө үзэмжийг сайжруулсан. Сумын төвд байдаг 23 айл хашаагаа тэгшилэн будаж оохордсон байна. | | |
| 6 | | Их боригдойн 2-р багийг антенн сүүлийн үеийн төхөөрөмж суурилуулан шинэчилж 4G сүлжээтэй болгоно. | 2020-2024 он | ЗДТГ/газрын даамал | Хувийн хэвшлийн зардал | | 4G Сүлжээтэй болгоно. | | 290.0 | Мобиком корпораци ХХК-ны Бүрд сумын Үнэгдийн “Сант хайрхан” гэх газарт үүрэн холбооны дамжуулах станц байгуулсан. Мөн ирэх 2023 онд Ширээт нуурын орчим байршилд үүрэн холбооны станц байгуулахаар төлөвлөж байна. | 100 | |
| 7 | | Төрийн байгууллагуудад ариун цэврийн байгууламжийг шинээр барина. | 2020-2024 он | ЗДТГ/газрын даамал | Улсын төсөв | | | | 390.0 | БШУЯамны төлөвлөгөөний дагуу цэцэрлэг, сургууль, эмнэлэгийн ариун цэврийн байгууламжийн ажил хийгдэж байна. ЗДТГ-ын ариун цэврийн байгууламжтай болгох талаар хүсэлт хүргүүлсэн. | 70 | |
| 8 | | Мааньт хороололын 04,022 кл ваттын цахилгаан дамжуулах | 2021-2024 | ЗДТГ/газрын | 41,3 сая ЭБЦТ | | 2021 онд Мааньт хорооллын | 41,3 | 41,3 | Төвийн дэд станцын 0.04/0.22 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг төмөр бетонон тулгууртай | 100 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | агаарын шугамыг шинэчлэнэ. /өндөр хүчдлийн шугамыг цэцэрлэгээс холдуулан барих/ | | даамал | Санцын ТӨХК өөрийн хөрөнгөөр | | агаарын шугам бүрэн шинэчлэгдсэн. | | | сип кабел утсаар сольж их засварын ажил хийгдсэн | | |
| 9 | | Сумын төвийг АО301 улсын чанартай авто замтай хатуу хучилттай замаар холбоно. | 2021-2024 | ЗДТГ/газрын даамал | Орон нутгийн төсөв | | | - | - | Хүсэлт хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулсан. | 70 | |
| 10 | | Хүүхдийн тоглоомын талбай байгуулна. | 2021-2024 | ЗДТГ/газрын даамал | Орон нутгийн хөгжлийн сан | | Тоглоомын талбай баригдсан байх | | 20.0 | ОНХС-ын хөрөнгөөр сумын төвд энэ онд хийгдэх "Хүүхдийн тоглоомын талбай" барих газрын байршил дээр "Захиргааны ерөнхий хуульд" заасны дагуу сумын иргэдээс 2 байршилд санал авч Мааньт хороололын баруун ШТС-уудаас чанх урд 150 метр төмөр хашаагаар хашаалж хүүхдийн тоглоомын талбай барьж хүлээлгэн өгсөн. Уг ажлыг С.Өсөхбаяр ахлагчтай " Өсөх ирээдүй" бүлэг гүйцэтгэсэн байна. | 100 | |
| 11 | | Аймаг, хот хооронд байнгын ажиллагаатай нийтийн унаатай болно. | 2021-2024 | ЗДТГ/газрын даамал | Хувийн хөрөнгөөр | | аймаг сум хооронд унаатай болно. | - | - | С.Ганбаатар хот хооронд байнгын үйлчилгээ үзүүлж байна. мөн Ц. Дашдагва аймаг, хот хооронд хүн, ачаа хүргэх үйлчилгээ хийж байна. | 100 | |
| 12 | | Нийтийн орон сууц барина | 2021-2024 | ЗДТГ/газрын даамал | | | | | | Хуучин дотуур байрыг дуудлага худалдаанд оруулж иргэн Ч. Сайнболд авч, нийтийн орон сууц барихаар төлөвлөн ажиллаж байна. | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | | Орон нутгийн судлах музейд засвар хийнэ | 2021-2024 | ЗДТГ/газрын даамал | | | | | 7.5 | Орон нутгийн судлах танхимын сум суртчилах танхимыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр дээвэр болон дотор заслыг хийсэн. Мөн музейн хашаан доторх амьтдыг сэргээн засварласан | 100 | |
| 1 | Зорилт 2. Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг эдийн засаг, нийгмийн хөгжил, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөж, газрын төлөв байдал, чанарын улсын баталгааг хийлгэх. | Хот суурингийн болон бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг үе шаттай хийлгэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. | 2020-2024 он | ЗДТГ/газрын даамал/ | Улсын төсөв Орон нутгийн төсөв | | | | 0.2 | Газрын мониторнгийн хээрийн судалгаа, мэдээлэл цуглуулах ажлыг 2021 оны 08 дугаар сарын 06-09 ны өдрүүдэд Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Мөнхбаяр , Цаг уурч Д.Пүрэвийн хамт хийж гүйцэтгэсэн. Хээрийн судалгааг дуусгаж фото мониторингийн мэдээлэл боловсруулахад гадаргуугийн бүрхэцийн зургийг мониторингийн цэг тус бүрээр нэгтгэж боловсруулалтын ‘’Sample Point’’ программ ашиглан ургамлын бүрхэцийн нийт хувь болон ургамлын бүлгээр ангилан тодорхойлсон. Эрх шилжсэн иргэн, аж ахуй нэгж байгууллагын газрын үнийн мэдээг газрын биржийн цахим системд цаг тухайд нь бүртгэн ажиллаж мөн газрын биржийн цахим системээр 2 дуудлага худалдааг зохион байгуулсан. | 100 | |
| 2 | | Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газрын кадастр, үнэлгээ, газрын мониторинг, биржийн байнгын ажиллагаатай | 2020-2021 он | ЗДТГ/газрын даамал/ | | | | - | - | 2022 онд Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан өвөлжөө 25, хаваржаа 25 нийт 3,5 га , өмчлөлийн 25 газраас 3 нь % гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 3 нэгж | 90 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | системийг хөтөлж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, газар олголт, газар зохион байгуулалтын үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй хэрэгжүүлнэ. | | | | | | | талбарын 2 нь эзэмшиж авсан байна.газрын кадастр, үнэлгээ, газрын мониторинг, биржийн байнгын ажиллагаатай системийг хөтөлж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, газар олголт, газар зохион байгуулалтын үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй хэрэгжүүлнэ.<br><br>2021 он газар зохион байгуулалтын төлөвлөгөөг 2020 оны 12 сарын 18-ны өдөр 03/02 дугаар тогтоолоор батлуулж газар зохион байгуулалтын цахим системд оруулсан. | | |
| 3 | | Сумын төвд хийгдсэн хаягийн зургийг засварлан, хаягжилтын мэдээллийн сан үүсгэж, төрийн байгууллагын мэдээллийн бусад сантай холбож, хаягжилтын ажлыг зохион байгуулна | 2020-2024 он | ЗДТГ/газрын даамал/ | Улсын төсөв | Хаягжилт хийгдсэн. | хаягжилтын мэдээллийн сангийн дагуу хаягын тогтоол шинэчлэн батлуулах | - | - | Хаягийн мэдээллийн санг засварлаж шинээр орц гарц, гудамжны эхлэл төгсгөлийн цэг, сумын төв болон багуудын төв цэгийг тодорхойлон ажиллаж байна. гэр хороололын хаягжилтыг тоотын дагуу дугаарлан хаягжуулсан. Сумын ИТХ-аар хаягжилтын мэдээлэлийн санг шинэчлэн батлуулсан. | 90 | |
| 4 | | Хот, суурины газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх зардлыг сумын ИТХ-аар батлуулан, орон нутгийн төсөвт тусгуулан гүйцэтгэнэ. | 2022-2024 он | ЗДТГ/газрын даамал/ | | | | | 45.0 | Төлөвлөгөөг хийлгэх хөрөнгийг сумын ИТХ-аар батлуулсан боловч , аймгийн Засаг дарга, УИХ-ын гишүүдээс хөгжлийн төлөвлөгөөг хийх шаардлагагүй гэж үзсэн учраас хийгдээгүй. | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | | Өвөлжөө хаваржаа эзэмшүүлэх журам боловсруулж, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар оруулж батлуулан ажиллах, | 2022-2024 он | ЗДТГ/газрын даамал | | | журам боловсруулж, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар оруулж батлуулах | - | - | Сумын бэлчээр ашиглалтын журамд оруулж батлуулна | 50 | |
| 1 | Зорилт 3. Сумын хэмжээнд газар зүйн нэрийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхижүүлж газар зүйн нэрийн хээрийн тодруулалтын ажлыг зохион байгуулж, газарзүйн нэрийн мэдээллийн сан бүрдүүлэн олон нийтэд танилцуулна | Газарзүйн нэрийн хээрийн тодруулалт, мэдээллийн сан үүсгэх, зураглал үйлдэх ажлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлнэ. | 2022-2024 он | ЗДТГ/газрын даамал | Орон нутгийн төсөв | | | - | - | Газарзүйн нэрийн хээрийн тодруулалт, мэдээллийн сан үүсгэх, зураглал үйлдэх ажлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэхээр ярилцаж төсвийн тооцоо хийж 2022 оны төсөвт суулгуулахаар хүсэлтийг өгсөн боловч хөрөнгө санхүүгийн асуудлаас хийгдээгүй байгаа. | 50 | |
| 2 | | Газарзүйн нэрийн мэдээллийн санг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулна. | 2020-2022 он | ЗДТГ/газрын даамал | Орон нутгийн төсөв | | | - | - | Сумын хилийн цэсийн газрын нэрийг тодруулж, АИХ-ын 1986 оны тогтоолын дагуу маргаантай цэг болох Монгол толгой асуудлаар Булган аймгийн Рашаант сумын удирдлагуудтай санал солилцсон. | 90 | |
| 3 | | Сумын хилийн цэсийн газрын нэрийг тодруулж, АИХ-ын 1986 оны тогтоолын дагуу баталгаажуулах | 2020-2024 он | ЗДТГ/газрын даамал | | | | - | - | Хугацаа болоогүй | | |
| **БҮЛГИЙН ДУНДАЖ** | | | | | | | | | | | **87,8** | |
| **ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.1.Ёс зүй, хариуцлагатай төрийн алба** | | | | | | | | | | | | |
| 1 | **Зорилт 1. Төрийн байгууллагуудын чиг үүргийг оновчтой тодорхойлж, давхардлыг арилгах, үйл ажиллагааны уялдааг хангах замаар үр ашигтай бүтэц бүхий мэргэшсэн чадварлаг, тогтвортой, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлнэ** | Төрийн албан хаагчийг тогтвортой ажиллах баталгааг хангаж, чадахуйн зарчимд суурилж, төрийн албаны хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, тэднийг чадвахжуулах , мэргэшүүлэхэд анхаарч ажиллана | 2021-2024 | ЗДТГ/ТГ-ын дарга/ | Байгууллагууд ын батлагд сан төсөв | ТЖАХ нар нийт 9-өөс 2 ньтүр томилго отой | ТЖАХ нарыг үе шаттайгаар УА-ын сургалтууд ад хамруулна. /2/ | | 11.4 | 2021 онд "Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт" онлайн сургалтанд Төрийн захиргааны албан хаагчид, төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтанууд 16 хүн хамрагдаад байна. Удирлагын академиас зохион байгуулсан "Алсын хараа—2050" богино хугацааны сургалтанд 1 хамрагдсан.<br>2022 онд төсвийн байгууллагын албан хаагчид, СИТХ-ын төлөөлөгчид зэрэг 130 гаран албан хаагчид хамрагдав .<br>Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй Пүрэв гаригын 4-7-10 сургалтанд Тамгын газар, ЕБС, цэцэрлэгийн хамт олон идэвхтэй хамрагдаж байна. Давхардсан тоогоор 643 албан хаагч хамрагдсан байна. Сумын хэмжээний төрийн албан хаагчдаас 4 албан хаагч баклаварын сургалтанд суралцаж , 1 албан хаагч баклавар төгссөн, 7 албан хаагч магистрын сургалтанд хамрагдаж байна.<br>ЗГХЭГ- захиалгаар Удирдлагын академиас зохон байгуулсан "Нутгийн захиргааны байгууллагын удирдлага, зохицуулалт" сэдэвт 24 цагийн цахим сургалтанд 1 албан хаагч, Удирдлагын академаас зохион байгуулж буй Мэргэшүүлэх | 100 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | дунд хугацааны чиглүүлэх сургалт 1 албан хаагч хамрагдав. | | |
| 2 | | Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ төлөвлөгөө, ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгон дүгнэж, мэдээллийн санг бүрдүүлнэ. | 2021-2024 | ЗДТГ/ТГ-ын дарга/ | Хөрөнгө шаардахгүй | ТАХ ажлыг үнэлж дүгнэдэг. | Төлөвлөгөө ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй сахилга хариуцлага гэсэн шалгуур үзүүлэлтээр үнэлнэ. | - | - | 2021 оны жилийн эцсээр төрийн албан хаагчдын үр дүнг үнэлж дүгнэхдээ гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй,хандлага, ур чадварыг ЗГХЭГ-ийн 2020 оны 100 дугаар тушаалын 10 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтээр үнэлсэн. 2022 оны тухайд ч төрийн захиргааны жинхэнэ албан хаагчдын хувьд мөн л иргэд, үйлчлүүлэгчээр үнэлүүлж байна. | 90 | |
| 3 | | Төрийн албаны сонгон шалгаруулалт, хүний нөөцийн томилгоо, сахилга хариуцлага, ёс зүйтэй холбоотой шийдвэрийг бүх байгууллагад ил тод, нээлттэй болгоно. | 2021-2024 | ЗДТГ/ТГ-ын дарга/ | Хөрөнгө шаардахгүй | Сумын сайтаар дамжуулж нийтэд мэдээлэлдэг. | Сонгон шалгаруулалт, томилгоо, ёс зүйн шийдвэрүүдийг нийтэд мэдээлж хэвшинэ. | - | - | 2021 онд ЗДТГ-т төрийн албаны ерөнхий шалгалтанд тэнцсэн 2 хүний туршилтын хугацаагаар томилсон. Мөн төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтан 2, засаг даргын орлогч, төрийн захиргааны удирдах албан тушаалтан зэрэг 4 хүний АТГ-т хянуулсан дүгнэлтийг сумын веб сайтад байршуулсан.<br><br>2022 онд суманд дутагдалтай байгаа төрийн захиргааны дутуу байгаа 4 / санхүүгийн албаны дарга, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн, маа-н асуудал хариуцсан мэргэжилтэн / орон тоо байгаа бөгөөд аймгийн төрийн | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | албаны зөвлөлийн салбар зөвлөлд захиалгыг хүргүүлсэн. Сумын пейж хуудасанд сул орон тооны зарыг тогтмол нийтэлж байна. Санхүүгийн албаны дарга, мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэнүүдийг мэргэжил нь ажлын байрны тодорхойлолттой нийцэж байгаа учраас ковидын нөхцөл байдлын үед төрийн албаны зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн дагуу түр томилгоо хийсэн байна. Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн Төрийн албаны зөвлөлөөс зарласан тусгай шалгалт өгч тэнцсэн. Төрийн үйлчилгээний албан хаагчдын орон тоо гарах бүрт байгууллагууд сул ажлын байрны зар нийтэд хүргэн сонгон шалгаруулан авч байна. 11 ажилтныг сонгон шалгаруулалтаар авсан байна. 2022 онд төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний удирдах 4 албан тушаалтаны ХАСУМ-ыг хянуулж burd.ov.gov.mn -д байршуулсан.<br>Төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг сумын цахим сайтад байршуулан ажиллаж байна.<br><br>Тамгын газарт дутагдалтай байгаа албан хаагчдын ажлын байрны захиалгыг аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлэн ажиллаж байна. Зарлаж | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | байгаа ажлын байрыг сумын албан ёсны пейж хуудсаар нийтэд мэдээлэн ажиллаж байна. | | |
| 4 | | Төсвийн ерөнхийлөн болон шууд захирагчийн төрийн албан дахь хөдөлмөрийн харилцаатай холбоотой шийдвэрийн эрх зүйн үндэслэлд тогтмол хяналт тавьж, зөрчил үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлнэ. | 2021-2024 | ЗДТГ/ТГ-ын дарга/ | Хөрөнгө шаардахгүй | ЗДТГ хянадаг байсан. | Төрийн албан дахьхөдөлмөрийн харилцаатай холбоотой шийдвэрийн эрх зүйн үндэслэлд тогтмол хяналт тавиж зөрчил дутагдал гаргахгүй байх. | | | Аймгийн Хууль эрх зүйн хэлтэст сумын засаг даргын үйл ажиллагаантай холбоотой 75, боловсон хүчинтэй холбоотой 13 захирамж, тамгын газрын даргын үйл ажиллагаатай холбоотой 22, боловсон хүчинтэй холбоотой 18 тушаалыг хянуулсан бөгөөд хяналтаар тодорхой зөрчил илрээгүй. Төсвийн байгууллагын дарга нарын тушаалыг Тамгын газрын хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн 1 удаа татан авч хянасан эрх зүйн үндэслэл зөрчил дутгалгүй бичиг эрхийг стандарт дээр алдаа дутагдал байсныг залруулахаар зөвлөмж хүргүүлсэн. | 100 | |
| **3.2.Цахим технологид суурилсан төрийн үйлчилгээ** | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Зорилт 1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийг хамгаалах, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг оновчтой арга, хэлбэрээр зохион байгуулна. | Иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар хүргэх операторын үйлчилгээг улам өргөтгөн , төрийн үйлчилгээг явуулын хэлбэрээр хүргэх үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | 2021-2024 | ЗДТГ/ улсын бүртгэгч/ | - | 85 | 190 | - | - | Иргэд харьяалал харгалзахгүй хаанаас ч төрийн үйлчилгээг нэг дороос авах нөхцөл бүрдэж 2021 онд Нийгмийн халамжийн 9 үйлчилгээ цахимд шилжиж давхардсан тоогоор 550 хүн хамрагдсан. Мөн операторын үйлчилгээнээс 277 төрлийн үйлчилгээг үзүүлэх боломжоор хангагдсан. 2021 онд 36, 2022 онд 45 хүнд төрийн үйлчилгээний нэгдсэн систем операторын үйлчилгээ үзүүлсэн байна. E-mongolia төрийн үйлчилгээний аплекшейнийг 80 иргэний утсанд суулгаж хэрхэн ашиглах талаар зааварчилгаа өгсөн. | 100 | |
| 2 | | Төрийн үйл ажиллагааг нь ил тод болгох, төрийн байгууллагуудын интернэтийн хурд, чанар ашиглалтыг сайжруулана | 2021-2024 | ЗДТГ төрийн бусад байгууллагуудын дарга нар | Орон нутгийн төсөв 3000,0 | | Интернет хурд сайн байх, сумын цахим сайт, пейж хуудсанд төрийн байгууллагуудын мэдээ мэдээлэл тогтмол мэдээлж байх. | 2,94 | 2.94 | Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг иргэдэд хүргэх зорилготой “Бүрд” сонинг 2 удаагийн гаргаж ард иргэдэд тараан олголоо. Мөн сумын burd.ov,gov.mn сайт, Бүрд сумын албан ёсны пейж хуудас, ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ олон нийтийн сүлжээгээр төрийн байгууллагуудын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж байна. 3 байгууллага МЦХТӨХХК-тай интернет ашиглалтын гэрээ байгуулан интернетийг дээд хурдаар авч байна. ЕБС БСШУЯ-аас, СӨББ гэр интернет ашиглаж байна. | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | | Төрийн байгууллагуудад дотоод удирдлагын нэгдсэн системийг нэвтрүүлж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагааг цахимжуулж, иргэд асуудлын шийдвэрлэлтийн явц, үр дүнг цахимаар хянах нөхцөлийг бүрдүүлнэ. | 2021-2024 | Төрийн байгууллагууд | . Хөрөнгө шаардахгүй | ТБ-уудын дотоод удирдлагын нэгдсэн систем нэвтрэх эхлэл тавигдсан | ТБ-уудын дотоод удирдлагын нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлэх | - | - | Төрийн байгууллагуудадын дотоод удирдлагын нэгдсэн платформ/ ERP/ -ийг ЗДТГ нэвтрүүлж эхэлж байна. Админы эрх, хүний нөөцийн ажилтны эрх зэргээ авч мэдээллүүдээ оруулж эхэлсэн. ЗДТГ-ын бүх албан хаагчид албаны майл хаягтай болсон. | 100 | |
| 4 | | Төрийн байгууллага хооронд болон тэдгээрээс иргэдтэй харилцах мэдээллийн солилцоо, ил тод байдлыг сайжруулж, бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. | 2021-2024 | Төрийн байгууллагууд | 1000,0 | | | | 5.3 | Төрийн байгууллагын дарга, ня-бо нар түргэн шуурхай мэдээлэл солилцох зорилготой фейсбүүк группүүд ашиглаж байгаагаас гадна 2021 оныг аймгийн ИТХ-аас “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан зорилтот жилийн хүрээнд хийж байгаа ажлын талаар Малчин телевизээр олон нийтэд нэвтрүүлэг бэлтгэн хүргэсэн. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт оруулах | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | санал, хүүхдийн тоглоомын талбайн байршил зэргээр иргэдээс цахимаар санал авснаас гадна “сумын төвийн дүрэм “-ээр нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав. | | |
| 5 | | 2, 3, 4, 5 дугаар багийн төвүүдийн барилгыг шинээр барих, 1 дүгээр багийн төвийн байрыг засварлах, Багийн засаг дарга нар болон төрийн байгууллагуудын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ЗДТГ | | 1-р багийн төв шаардлага хангасан байртай | 1 | | 19.3 | 2-р багийн төвийг шинээр барих, 1,3 -р багийн төвийг засварлах төсөв тооцоог гаргасан. 2022 оны ОНХС-ийн хөрөнгөөр 2-р багийн иргэний танхимыг барих ажлыг тусган, тендерийг цахимаар зарласан боловч, тендерт оролцох аж ахуйн нэгж ирээгүй байна. багийн дарга нарт 5ш, ЗДТГ-т суурин 1, зөөврийн 3, өнгөт принтер, ИТХ-д суурин 1 ш компютераар хангагдсан байна | 100 | |
| 6 | | Төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа сурталчлах зардлыг жил бүр төсөвтөө тусган, мэдээллийн ил тод байдлыг хангахад хяналт тавьж, иргэдэд үнэн бодит мэдээлэл түгээх, нийгмийг соён гэгээрүүлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч, “Нэг цонхны мэдээлэл” үйл ажиллагааг үр дүнтэй нэвтрүүлнэ. | 2021-2024 | ЗДТГ | 450,0 | Вэйб сайт хөтлөгдд өг. | Жилд 2 удаа сонин гаргах, вэйб сайтыг хөтлөх | 3.4 | 3.4 | Сумын веб сайтыг хөгжүүлэхэд жил бүр 280,0 мян.төг зарцуулж байна . Веб сайт хэвийн ажиллаж байна. 2022 онд “Бүрд” сонинг 2 удаа гаргасан. | 100 | |
| 7 | | Төрийн байгууллагуудын дотоод хяналт, шалгалтын нэгжийн үйл ажиллагааг | 2021-2024 | ЗДТГ | | Байгууллага бүр дотоод | Байгууллага бүр дотоод хяналт | | | 2021 онд ЗДТГ 2022 оны 02 дугаар сард Байгууллагын төсөв санхүү, үйл ажиллагаа, нийцлийн буюу эрх | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тогтмолжуулж, гүйцэтгэлийн хяналт, үр нөлөөг нэмэгдүүлнэ. | | | | хяналт шалгалтын нэгж байгуулан ажиллаж байгаа | шалгалтын нэгжийн үйл ажиллагааны төвлөвлөгөө батлуулан улиралд 1-2 хяналт шалгалтыг хийсэн байна. | | | зүйн зохицуулалт, гадаад дотоод орчин гэсэн чиглэлээр эрсдэлийн үнэлгээ хийн тус үнэлгээн дээр тулгуурлан 4 бүлэг бүхий төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллаа. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу эд хөрөнгийн бүртгэл болон ашиглалт хамгаалалт, орон нутгийн хөгжлийн сангийн журам, ундны усны чанар аюулгүй байдал, Хүнсний аюулгүй байдал, Төсөвт байгууллагын дарга нарын боловсон хүчний шийдвэр зэрэгт хяналт шинжилгээ хийж ажиллаа. Мөн Засгийн газрын 2011 оны “нийтлэг журам батлах тухай” 311 дүгээр тогтоолтой уялдуулан Дотоод хяналтын нэгжийн ажиллах журмыг боловсруулж мөрдлөг болгон ажиллаж байна.<br>Бусад төрийн байгууллагууд дотоод хяналтын нэгж байгуулан , байгууллагын дарга нар төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | | |
| 8 | | Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гарсан зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах үүрэг чиглэл өгч тухай бүрт хэрэгжүүлэх арга авч үр дүнг тооцон ажиллана. | 2021-2024 | ЗДТГ | | Жилд 1 удаа ХШҮ хийдэг | Жилд 2 удаа ХШҮ хийсэн байна. | | | ЗДТГ-ын дотоод хяналтын нэгж төлөвлөгөөний дагуу 5 удаа хяналт шалгалтын ажил хийж зөвлөн тусалсан | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.3.Эрх зүйн боловсролтой иргэн, хүний эрхийг хангасан нийгэм, авлигагүй засаглал** | | | | | | | | | | | | |
| 1 | **Зорилт 1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийг хамгаалах, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг оновчтой арга, хэлбэрээр зохион байгуулна. Улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу эрхлэн хөтөлнө.** | Цахим технологид суурилсан арга хэлбэрээр хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааг зохион байгуулж, “Бүх нийтийн эрх зүйн боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ЗДТГ | | | | | | Бүрд сумын албан ёсны пейж хуудас, ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БҮРД СУМЫН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ, байгууллагын дотоод сүлжээ зэрэг олон нийтийн сүлжээгээр дамжуулан шинээр батлагдсан хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм журмыг нийт 23 цахимаар хүргэж ажиллаа. | 90 | |
| 2 | | Төрийн болон иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-үнэлгээ хийж, шийдвэр гаргахдаа аливаа хэлбэрээр ялгаварлахгүй, ашиг сонирхлын зөрчилд автахгүй, хязгаарлал, давуу байдал тогтоохыг хориглоход анхаарч ажиллана. | 2021-2024 | ЗДТГ-ын дарга | | 2 | 2 | | | Засаг дарга, төрийн байгууллагын дарга Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1 / Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана./ гэсний дагуу | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | 2021, 2022 онд 290 удаа мэдэгдэл тайлбар гаргаж, түүнийг цахим санд өүртгэсэн байна. | | |
| 3 | | Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн, олон талт арга хэмжээг зохион байгуулж үр дүнг олон нийтэд мэдээлж ажиллана. | 2021-2024 | ЗДТГ | | 0 | 2 | | | Хүний эрх эрх чөлөө зөрчсөн аливаа шийдвэр гараагүй. Хүний эрх , эрх чөлөөтэй холбоотой мэдээ, мэдээллийг цахим орчинд нийтэд мэдээлж байна. | 70 | |
| 4 | | Суманд хэрэглэгчийн эрхийг хамгаалах, шударга бус өрсөлдөөнтэй тэмцэх үүрэг бүхий салбар зөвлөл байгуулж , хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг үйл ажиллагааг идэвхжүүлэн, бизнесийн байгууллагуудын шударга бус өрсөлдөөн, үнийн хөөрөгдөл, бүтээгдэхүүний чанар байдлыг хянаж, монополь үүсгэхээс сэргийлж ажиллана. | 2021-2024 | ЗДТГ | | Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зөвлөл байхгүй. | 2 | | | Засаг даргын захирамжаар хэрэглэгчийн эрхийг хамгаалах зөвлөл байгуулсан. Суманд үйл ажиллагаа явуулж буй 3 шатахуун түгээх, 8 нэрийн 5 дэлгүүр, 6 нэрийн 3 дэлгүүр хамруулан ажилласан.<br>Хяналтын явцад и-баримт олгогдох байдал, бүтээгдэхүүний хадгалалт, хугацаа, үнийн нэмэгдэл зэргийг шалгалаа.<br>Нийт зөрчил дутагдал: шатахуун түгээгүүрийн газрууд и-баримт олголт муу байгаа ард иргэдийг нэхэхгүй бол өгдөггүй, мөн чанарын үзүүлэлтийг үзүүлэх бичиг баримт дутуу байгаа. Хүнсний дэлгүүрүүдэд хугацаа нь хэтэрсэн хүнсний бүтээгдэхүүн илэрсэн / үүнд Тэнгэрийн оргилго 250000, Их Бүрд 200000/ бөгөөд устгал болон буцаалтын арга хэмжээ авахыг зөвлөн бүртгэл хийсэн. 1 | 70 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | дэлгүүрийн агуулах хүнсний бүтээгдэхүүн хадгалах шаардлага хангахгүй байсан учир хугацаатай үүрэг даалгавар өгсөн. 10 сард хийгдэх стандарчлал хэмжил зүйн албанаас тохирлын гэрчилгээний шалгалтаар шаардлага хангах эсэхийг шийдвэрлэнэ. | | |
| 5 | | Улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу эрхлэн хөтөлж , иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулах. | 2021-2024 | ЗДТГ /Улсын бүртгэл / | Хөрөнгө шаардахгүй | Иргэдэд чирэгдэлгүй үйлчилж байсан. | Иргэдэд улсын бүртгэл үнэн зөв хөтлөгдөж иргэдэд үйлчилгээг хүртээмжтэй хүргэсэн байна. | - | - | 2021онд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр төрөлт-41, эцэг тогтоолт-2, гэрлэлт-8, нас баралт -16, шилжилт хөдөлгөөн -33, иргэний шинэчилсэн бүртгэл-97, иргэний үнэмлэх олголт -135, иргэний үнэмлэх дахин авалт -26, иргэний улсын бүртгэлийн лавлагаа -56 тус тус нийт 414 иргэнд бүртгэлийн үйлчилгээг хууль тогтоомжийн хүрээнд үзүүлж, иргэдийн мэдээллийг тухай бүрт онлайн системд бүртгэж баталгаажуулсан байна. 2022 онд төрсний бүртгэлд-41, үрчилсний бүртгэлд -1, эцэг тогтоолт-2, гэрлэсний-11, нас барсны -12, шилжилт хөдөлгөөний -20, шинэчилсэн бүртгэлд -97, иргэний үнэмлэх олголт-111 – иргэн тус тус бүртгэлд бүртгэлд хамрагдсан . Төрсний гэрчилгээ дахин олголт-10, иргэний улсын бүртгэлийн лавлагаа -96, иргэний үнэмлэх дахин -10, Нийт 411 иргэнд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг хуулийн дагуу үзүүлж , 551 хуудас нотлох баримтыг | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хуулийн хугацаанд цахимжуулсан байна. Мөн Газар өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг-5 иргэнд олгосон . Цахим гарын үсгийн тухай хууль 2022 оны 5 дугаар сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 16-аас дээш насны иргэн бүрт үнэ төлбөргүйгээр 5 жилийн хугацаатайтай олгох зорилт тавьж байгаа бөгөөд одоогийн байдлаар 769 иргэнд олгоод байна. | | |
| 1 | Зорилт 2. Олон нийтийг соён гэгээрүүлэх замаар авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэн, тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | Авлигыг үл тэвчих үзэл хандлагын талаарх нийтлэл, нэвтрүүлгийг цахим сүлжээ болон хэвлэл мэдээллийн байгууллагаар олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажил зохион байгуулна. | 2021-2024 | ЗДТГ | Хөрөнгө шаардахгүй | 15 | 36 | - | - | АТГ-ын “Олон нийтийн төв”-ийн Өнөөдөр “ашиг” олж байгаа мэт санагдавч #авлигын хор уршгийг бүх нийтээрээ төлдөг...<br><br>Бусдын #боломжийг_бүү_хулгайл ❗ , Авлигаас хэн ч хождоггүй…, Үнэний ҮНЭ үгүй болсон энэ цагт<br><br>Үүргээ ухамсарлан ТА шүглээ ҮЛЭЭ...<br><br>#110 #ШүглээҮлээ #ИлчилжАВАР зэрэг контентууд, 10 дугаар сарын 11-ны мэдээлэл, #Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа #110 #Гомдол_мэдээлэл_хүлээн_авах_утас, #Зөв_зөвд_шударга_зөв зурагт хуудас зэргийг Өвөрхангай аймгийн Бүрд сумын албан ёсны пейж хуудсаар дамжуулан нийтэд мэдээлсэн. | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | ЗДТГ ,ЕБС,СТ, ЭМТ зэрэг байгууллагуудад авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зурагт хуудаснууд байрлуулсан, авилга ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх гарын авлаг материалыг 50 төрийн албан хаагчдад тарааж олгосон. | | |
| 2 | | Хүүхэд, залуучуудад авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах сургалт, сурталчилгаа зохион байгуулж, авлигыг үл тэвчих үзэл хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр боловсролын байгууллагатай хамтран олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ЗДТГ | Хөрөнгө шаардахгүй | 2 | 3 | - | - | Тус сумын сургуулийн “Өвөрхангай Бүрд сумын Д.Пүрэвдоржийн нэрэмжит, аймгийн тэргүүний ЕБС” олон нийтийн сүлжээнд АТГ-ын 2 видео шторкийг байрлуулсан. 12 сард зохион бичлэгийн уралдаан зохион байгуулахаар төлөвлөөд байна.<br>Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад “Дэлхийн авлигын “ эсрэг өдөр буюу 12 сарын 09 өдөр Бага ангид “Авлига миний нүдээр” | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | дунд, ахлах ангиудад “Авлига, түүний хор уршиг” сэдэвт хичээлийг зохион байгуулж, Авлигын эсрэг тухай хууль, тогтоомжуудыг байгууллагын мэдээллийн самбарт байршуулж мөн ахлах ангийн сурагчдын дунд Авлига ба шударга ёс хэлэлцүүлэгийг зохион байгуулж ажилласан. Нийт давхардсан тоогоор 410 сурагч хамрагдсан байна | | |
| 3 | | Сумын авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган, үр дүнг тооцон ашиг сонирхлын зөрчил гаргуулахгүй байх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ЗДТГ | Хөрөнгө шаардахгүй | 1 | 1 | - | - | АТҮХ-ийн 2021 оны хэрэгжилтийг 92,1%, 2022 оны хэрэгжилт 91,8%тай байна гэж дүгнэсэн. Авилгаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлан төлөвлөгөөг аймгийн Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлсэн. | 100 | |
| 1 | **Зорилт 3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хамгаалах цогц арга** | Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ | 2021-2024 | ЗДТГ - | | 70 | 100 | | 4,0 | “Амар тайван Өвөрхангай” дэд хөтөлбөрт хувийн хэрэг нээн хэрэгжилтийг хангах төлөвлөгөө гарган ажиллаж байна. Хөтөлбөрийн хэрэгжилт 87,1%-тай байна<br>Цагдаагийн хэсгийн алба хаагчдын ажиллах нөхцөл болоцоогоор хангаж сар тутамд ЗДТГазраас 50 летр шатахуун ИТХурлаас сар бүр 20 летр шатахуун интернетийн төлбөрийг бүрэн хариуцаж байна. Мөн Хархорины цагдаагийн | 90 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **хэмжээ авч хэрэгжүүлж, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг сайжруулна.** | | | | | | | | хэлтсээс ажлын тог цахилгааны төлбөрийн 50 хувийг төлж байна. | | |
| 2 | | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хамгаалах ажилд хөршийн холбоо, гудамжны ахлагчийг ажиллуулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн, сумын төвийн гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн зам, талбайн гэрэлтүүлэг, теле-камерын хяналтын системийг хөгжүүлнэ. | 2021-2024 | ЗДТГ | | | | 2,8 | 6.63 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хамгаалах ажилд 10-тын системийг байгуулан ажиллаж байна. 5-р багийн Засаг даргын захирамжаар хөршийн холбоо, гудамжны ахлагчийн томилон ажиллуулж олон нийтийн оролцоог гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд оролцуулж эхэлж байна.<br><br>Сумын төвд гудамжны 47 гэрэл, 3ш гэрэлт цамхаг асч байна.Мөн Бүрд сум 5-р баг чигчий хороололд 2022 оны 6 ширхэг гэрэлтүүлэг нэмж байршуулсан.<br><br>Сумын хэмээнд нийт 25 хяналтын камераас хэвийн ажиллагаатай 4 камер байсан ба ажиллахгүй байсан 21 камерыг 2.300.000 төгрөгний | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | засвар хийлгэж ажиллагаатай болгосон.<br>Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд 440.000 төгрөгөөр хяналтын 2 ширхэг камерыг иргэдийн төлөөлөгчдын хурлаас шийдвэрлэж авч өгсөн байна. ЗДТГ 4, ЭМТ 5 камер шинээр суурилуулсан. | | |
| 3 | | Шарлинд байрлах шатахуун түгээх станц, Хөөврийн гүүр зэрэг газруудын тээврийн хэрэгслийн зогсоолын цэгүүдэд теле-камер байрлуулах, хурд сааруулагчтай болгох, тээврийн хэрэгслийн улсын дугаар танигч LPR камерыг суурилуулах ажлыг аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоотойгоор шийдвэрлэнэ. | 2021-2024 | ЗДТГ | 3200,0- | | Хурд сааруулагч-1 | - | - | Шарлин дах ШТС, 5 дэлгүүр 3 ШТСтанц камер суурилуулсан.<br>Хурд сааруулагч хөрөнгө шаардах учраас хэрэгжих хугацаа болоогүй. Шулуун замд хурд сааруулагч тавих шаардлагагүй, анхааруулга тэмдэг тавигдах шаардлагатай. | 90 | |
| 4 | | Нийгэмд түгээмэл буй архидан согтуурах, зам тээврийн осол, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдийг бууруулах, таслан зогсоох олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ЗДТГ | Орон нутгийн төсөв | | Архинаас үүдэлтэй гэмт хэрэг зөрчлийн тоо буурсан байна. | 4,0 | 4,0 | 2021 онд Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх жилийн ажлын төлөвлөгөөнд тодорхой ажил төлөвлөн ажилласан. Архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ нийгмийн хэв журам зөрчсөн 38 хүнд Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ авсан. ЗДТГ-т хүүхэд хамгааллын байртай болсон. Гэр | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | бүлийн хүчирхийлэл үйлдсэн 2 иргэнийг Хархорин сум дах сум дундын шүүхээр баривчлуулах ялаар шийтгүүлсэн. Тарны гүүрийн пост болон Есөн зүйл сумын замын гарц зэрэгт 7 хоногт 2-3 удаа сумын цагдаагийн байгууллагын албан хаагчид гарч ажилладаг. Хөдөө орон нутгийн эвдэрсэн замуудад 5 анхааруулах тэмдэглэгээ авчирч байрлуулсан.<br><br>2022 онд Зөрчлийн тухай хуулийн 5.1.2-ийг зөрчсөн 50 хүнийг 1250.000 , 5.1.1 заалтаар 18 хүнийг 180.000, 5.3.1-ээр 1 хүнийг 100.000 төгрөгөөр бүгд 1.530.000 торгож ажилласан. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 3 иргэнийг Хархорин сум дах сум дундын шүүхээр баривчлуулж арга хэмжээ авахуулсан ба хувийн хэрэг нээн ажиллаж байна. Архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ замын хөдөлгөөнд оролцсон 22 иргэнийг Хархорин сум дахь сум дундын шүүхээр 7-30 хоногоор баривчлуулсан. Мөн 3 жолоочийг эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж 1.200.000 төгрөгөөр торгож, эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 3 иргэнийг 600,000 төгрөгөөр торгосон байна.<br><br>Тарны гүүрийн пост болон Есөн зүйл сумын замын гарц зэрэгт 7 хоногт 2-3 удаа сумын цагдаагийн | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | байгууллагын албан хаагчид гарч ажилладаг. Хөдөө орон нутгийн эвдэрсэн замуудад 5 анхааруулах тэмдэглэгээ авчирч байрлуулсан.558 жолоочид 10.495.000 төгрөгний торгуулийн арга хэмжээ авч ажилласан. | | |
| 5 | | Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажилд төрийн зарим байгууллагуудыг татан оролцуулж, мал бүрийг бүртгэлжүүлэх, мал, махны гарал үүслийн гэрчилгээ олголтыг цахимжуулах, малчдын бүлэг, нөхөрлөлийг чадавхжуулах зэрэг цогц арга хэмжээ авч хэрэгжүүлж, мал хулгайлах гэмт хэргийн гаралтыг эрс бууруулна. | 2021-2024 | ЗДТГ | . | | | | | Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, хөдөлмөрөө хорших чиглэлээр малчдын 10-тын бүлгүүд 46 байгуулагдаж, 7 хоногт 1 удаа бүлгийн гишүүд хариуцсан нутаг дэвсгэртээ эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.. Мөн бог, бод малыг ээмэгжүүлэхээр 20 гаран мянган ээмэг авсан. /2021 он гарсаар сумаас зах зээлд нийлүүлэгдсэн мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нийт 1137 гэрчилгээнд баталгаажуулалт хийсэн байна. 2020 онд малын хулгайн гэмт хэрэг 5 гарч байсан энэ жил 3 гарч буурсан , 2021 онд малын хулгайн гэмт хэрэг 3 гарч байсан 2022 онд 1 гарч буурсан байна. Тарны гүүр, Шарилан зэрэг газруудын авто зам дээр эргүүлээр ажиллах болон суурин газрууд руу борлуулж байгаа мал махны гарал үүсэлд байнга хяналт тавин ажиллаж байна. | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Зорилт 4. Хууль сахиулах байгууллагын алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.** | Сумын төрийн байгууллагуудын архивыг зориулалтын өрөө тасалгаатай болгож, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд хүргэх үйлчилгээг хялбаршуулна. | 2021-2024 | ЗДТГ | | | Байгууллагуудын архивын өрөө тасалгааг | | 3,1 | Төрийн байгууллагууд зориулалтын архивын өрөөтэй болсон. ЗДТГ скайнер, цаас зүсэгч зэргийг шинээр авч, баримт үдэгчийн ремен, ЕБС бичиг баримт хадгалах хавтас 50ш, принтер, шат, дулаан хэмжигч, баримтын тавиур 1 ш, тоног төхөөрөмжөөр хангагдсан. | 100 | |
| 2 | | Олон нийтийн цагдааг орон тоогоор ажиллуулна. | 2021-2024 | ЗДТГ | 4500 | 1 | 1 | - | - | Тус суманд олон нийтийн цагдаа ажиллуулах зар мэдээг удаа дараа хүргэж ажилласан бөгөөд 2021 онд ажиллах иргэн бүртгүүлээгүй. 2022 онд 1 иргэн ажиллахаар бүртгүүлэн 2022 оны 11 сарын 08-аас Өвөрхангай аймгийн Цагдаагийн газарт 1 сарын сургалтад хамрагдаж байгаа. Сургалтаа төгсөн үнэмлэх тэмдэг авснаар ажиллах эрх зүйн орчин бүрдэж сумандаа ажиллана. | 90 | |
| 3 | | Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон тээврийн хэрэгсэл саатуулах журмын хашаатай болох. | 2021-2024 | ЗДТГ | | 0 | 1 | | | Гэмт хэрэг зөрчил холбогдсон тээврийн хэрэгслийг саатуулах журмын хашаагүй байна.Шаардлагтай тохиодолд | 50 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | албаны машины граш, ЗДТГ-ын хашаанд оруулж саатуулж байна. | | |
| 4 | | Сумын газар нутаг дэвсгэрт салдаг замын уулзварууд, сумын төвийг тэмдэгжүүлэх. | 2021-2024 | ЗДТГ | - | | тэмдэгжүүлэх | | | Сумын нутаг дэвсгэрийн салдаг замын уулзвэруудад байрласан замын тэмдэг тэмдэглэгээнүүдэд нөхөн сэргээлт хийсэн. Нийслэлийн авто замын хөгжлийн газраас 5 замын тэмдэглэгээг авч эвдрэл ихтэй замуудад 4 -ыг нь байрлуулсан. | 100 | |
| 5 | | Сумын хэмжээнд телехяналтын камер, гэрэлтүүлэггүй газарт гэрэлтүүлэг, камер суурилуулах. | 2021-2024 | ЗДТГ | | | Гэрэлтүүлэг камер суурилуулах | 20,6 | 20,6 | 2021 онд ЕБС-ийн дотор болон гадна 28 камер, Цэцэрлэг гадна болон дотор 12, сургуулийн дотуур байранд шинээр 4 , 2022 онд ЗДТГ 4, ЭМТ 4, дотуур байрны гадна талд 1 ш камер шинээр суурилуулж, гэр хороололд 21 камерыг засаж ашиглалтанд оруулсан байна.<br><br>2021 онд гэр хорооллын асахгүй байсан 21 ш гэрэлтүүлгийг засварлаж, 2022 онд чигчий хороололд 5 ш гэрэлтүүлэг шинээр суурилуулсан. Нийт 25 камерт цагдаагийн албан хаагчид хяналт тавьж байна. | 100 | |
| **3.4.Гадаад харилцаа, хамтын ажиллагаа** | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Зорилт 1. Сумын уламжлалт гадаад харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн тэргүүлэх салбарын харилцааг хөгжүүлнэ.** | Суманд гадаадын хот, мужуудтай харилцаа тогтоох, олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай идэвхтэй ажиллагааг өрнүүлэх, эдийн засаг, нийгэм ХАА салбарт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд сумаас дэмжлэг авах. | 2021-2024 | ЗДТГ | | | | | | Дэлхийн банктай хамтарсан “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төслөөс малын гоц халдварт өвчнийг эрт илрүүлэх тандалт шинжилгээ хийх дээр хамтран ажиллаж байна. | 70 | |
| 2 | | Японы Насу хотын ОШИМА Форумын хүүхэд солилцооны хамтын ажиллагааг үргэлжлүүлэх. | 2021-2024 | ЗДТГ | | Жил бүр хүүхэд солилцооны хөтөлбөр хэрэгжидэг уламжлалтай | Жилд 2 хүртэл хүүхдийг хүүхэд солилцооны хөтөлбөрт хамруулна. | | | Коронавируст халдвар Ковид-19 цар тахлаас шалтгаалан хүүхэд солилцооны хамтын ажиллагаа түр хойшилсон. | 0 | |
| **3.5.Батлан хамгаалах, гамшгаас урьдчилан сэргийлэх** | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Зорилт 1. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэн, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилж, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.** | Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүнтэй төлөвлөгөөний дагуу сургалт, бэлтгэлийг зохион байгуулж, үүрэг гүйцэтгэх мэдлэг, дадлага олгоно. | 2021-2024 | ЗДТГ | Хөрөнгө шаардахгүй | Хууль хэрэгжиж эхэлсэн | Томилгоот нэгжүүдэд сургалт зохион байгуулсан байна. | - | - | 2021 онд Орон нутгийн томилгоот нэгжийг төлөвлөгөөнд заасны дагуу байгуулсан. Аймгийн цэргийн штабтай хамтран томилгоот нэгжүүдийн бэлэн байдлыг шалгаж сургалт сумын төвд зохион байгуулав. Энэ арга хэмжээнд 25 иргэн, 5 автомашин, 5 мотоцикл хамрагдав. 2022 онд Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Орон нутгийн хамгаалалтын нэгжийн анхдагч дадлага, сургуулилт”-д сумын Засаг даргын орлогч оролцсон. Мөн орон нутгийн томилгоот нэгжийн томилгоог шинэчлэсэн. | 100 | |
| 2 | | Сумын дайчилгааны төлөвлөгөө болон томилгоот байгууллага, аж ахуйн нэгжийн дайчилгааны даалгаврыг шинэчлэн боловсруулж, бэлэн байдлыг хангана. | 2021-2024 | ЗДТГ | | . Хууль хэрэгжиж эхэлсэн | Томилгоот нэгж байгууллага, аж ахуй нэгжүүд дайчилгааны даалгаврын дагуу бэлэн байдлаа хангасан байна | - | - | Сумын дайчилгааны төлөвлөгөө болон томилгоот байгууллага, аж ахуйн нэгжийн дайчилгааны даалгаврыг шинэчлэн боловсруулж, бэлэн байдлыг хангасан. | 100 | |
| 3 | | Ерөнхий боловсролын сурагчдад цэрэг-эх оронч үзэл хандлага төлөвшүүлэх | 2021-2024 | ЗДТГ | Хөрөнгө шаардахгүй | хэрэгжээгүй | Орон нутгийн төсөвт тусгуулах | - | - | Бүрд сумаас энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцсон цэрэг дайчид офецеруудыг алдаршуулах үйл ажиллагаа мэдээлэл бэлтгэн, сум сургуулийн цахим хуудсанд | 100 | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
